



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1964 оны 3 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар
хот

Хотын гүйцэтгэх захиргаанд
орлогч даргын орон тоо
нэмэгдүүлэх тухай

Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний ёсоор барилга байгууламж, хот тохижуулах ажлын хэмжээ эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан, хотын нийт барилга, тохижуулалтын ажлын удирдлага, захиалагчийн хяналтыг сайжруулах зорилгоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд барилгын ажил эрхэлсэн орлогч даргын орон тоог бий болгож, сарын цалинг 1200 төгрөгөөр тогтоосугай.

2. Хотын гүйцэтгэх захиргааны барилгын ажил эрхэлсэн орлогч даргад хотын барилгын хэлтэс, хотын архитектур-төлөвлөгөөний газар, хот тохижуулах газар, зам ашиглалтын ангийг хариуцуулсугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн I-р орлогч дарга
Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын дарга

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч

ЛУВСАН

БАДАРЧ

Б.А.Дорж

/ДАГВАДОРЖ/

НИЙЛСЭН.....
цохисон Мөнхөө